



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 25-21-35,
Факс: (976-11) 32-21-27, E-mail: info@mfa.gov.mn,
http://www.mfa.gov.mn

КАНАД

ЗБ № *09/6232*
танай _____-ны № _____-т


Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас Канад Улсын иргэдийг 30 хүртэл хоногийн хугацаанд Монгол Улсад визгүй зорчихыг зөвшөөрсөн шийдвэр дангаараа гаргасан тухай төлөөний ноотыг Гадаад харилцааны сайд Л.Болд 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Канад Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Г.Голдхаукт гардуулсан болно.

Засгийн газрын энэхүү шийдвэр нь 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэх тул Канад Улсын иргэдийг саадгүй нэвтрүүлэх, Олон улсын агаарын тээврийн байгууллагад мэдэгдэх зэрэг холбогдох арга хэмжээ авахыг хүсье.

Хавсралт: Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, ноот бичгийн хуулбар

ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ



Б.МАНДАХБИЛЭГ

8000003898

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэлд:

"IX.2. ХЭЛЭЛЦСЭН нь: Канад Улсын иргэдийг визээс чөлөөлөх тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 2.1. Монгол Улсад 30 хүртэлх хоногийн хугацаанд зорчих Канад Улсын иргэдийг визээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцээд зүйтэй гэж үзэн Канад Улсын Гадаад хэргийн яаманд Ноот бичгээр мэдэгдэхийг Гадаад харилцааны сайд Л.Болдод зөвшөөрөв.

2.2. Канад Улсын иргэдийг 30 хүртэлх хоногийн хугацаанд визгүй зорчуулах ажлыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны сайд Л.Болд, Хууль зүйн сайд Х.Тэмүүжин нарт даалгав.

2.3. Үүнтэй холбогдуулан Монгол Улсаас Канад Улсад суугаа Элчин сайдын яамны төсвийг нөхөх талаар арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Гадаад харилцааны сайд Л.Болд нарт даалгав." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Т.Амгалан
Төрийн газрын
нь зөвшөөрөх
О. 19/3.



MONGOLIA
MINISTRY OF FOREIGN AFFAIRS

A/13-1898

Монгол Улсын Гадаад харилцааны яам Канад Улсын Гадаад хэрэг, худалдаа, хөгжлийн яаманд гүн хүндэтгэлээ илэрхийлэхийн ялдамд Монгол Улсын Засгийн газар 2013 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаас Канад Улсын иргэдийг 30 хүртэлх хоногийн хугацаанд Монгол Улсад визгүй зорчихыг зөвшөөрч, зохих шийдвэр гаргасныг мэдэгдэх завшаан тохиов

Энэ шийдвэр 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

Энэхүү завшааныг ашиглан Монгол Улсын Гадаад харилцааны яам Канад Улсын Гадаад хэргийн яаманд нэн өндөр хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.



Улаанбаатар хот,
2013 оны 10 дугаар сарын 15-ны өдөр

КАНАД УЛСЫН
ГАДААД ХЭРЭГ, ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН
ЯАМАНД
Оттава

14210 Peace Ave. 7a
Ulaanbaatar, MONGOLIA

Tel: 976-51-262135, Fax: 976-11-322127
E-mail: info@mfa.gov.mn

http://8000008725

Translation from Mongolian

Note Verbale

The Ministry of Foreign Affairs of Mongolia presents its compliments to the Department of Foreign Affairs, Trade and Development of Canada and has the honour to inform that the Government of Mongolia has taken decision on 12th of October, 2013 to allow the citizens of Canada to enter and stay in the territory of Mongolia for up to thirty (30) days.

This decision will take effect from 1st of January 2014.

The Ministry of Foreign Affairs of Mongolia avails itself of this opportunity to renew to Department of Foreign Affairs, Trade and Development of Canada the assurances of its highest consideration

Ulaanbaatar,

October 15th, 2013

DEPARTMENT OF FOREIGN AFFAIRS,
TRADE AND DEVELOPMENT OF CANADA
Ottawa